



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/232

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Хүүхдийн эрхийн тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.5.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Японы Хүүхдийг Ивээх сангийн санхүүжилтээр 2021 оны 06 дугаар сараас 2022 оны 03 дугаар сар хүртэл хэрэгжүүлэх “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг дэмжих нь” төслийг орон нутагт удирдан чиглүүлж, хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Норовсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Насан
туршийн боловсролын төвийн сургалтын менежер)

Гишүүд: С.Долгорсүрэн (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн боловсролын салбарын бодлого зохицуулалт
хариуцсан ахлах мэргэжилтэн)

Г.Мөнх-Эрдэнэ (аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн
газрын Хүүхдийн эрх хөгжил, хамгаалал, нийгмийн ажилтан,
хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал
хариуцсан мэргэжилтэн)

Г.Оюунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамж, үйлчилгээний
газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Э.Хоролсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын
хөгжлийн газрын гэр бүлийн асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн)

С. Ганчимэг (Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Д.Долгормаа (Хархорин сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

З. Дагвасүрэн (Уянга сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Г.Батцэцэг (Японы Хүүхдийг Ивээх сангийн төслийн ажилтан)

2. Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, явц үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд мэдээлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Сайнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ

011100600

D:My Doc. Zahiramj. Zasag darga